

**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРААС ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН
НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД
2022 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт
Зорилт 1: Албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүрэг, хөдөлмөрийн гэрээнд заасан эрх, үүрэг, гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах ажлын байр, эрүүл ахуйн нөхцөл, бичиг хэргийн хэрэгсэл, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд нийцсэн техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, эд материал, ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл, мэдээллээр хангах зорилтын хүрээнд:		
1	Ажлын байрны дотоод орчныг шат дараалалтай сайжруулах, эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх	Ажлын байрны эрүүл ахуйн нөхцөлийг ханган, цэвэрлэгээ, ариутгалыг хийж ажиллаж байна. Цэвэрлэгээ, ариутгалын бодис авахад 3.207.800 төгрөг зарцуулсан. Ажлын байрны орчныг сайжруулах чиглэлээр: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан шат, төв байрны дээврийн засвар, хурлын заалны засвар, коридорын засварын ажил хийсэн. Үүнд 42.687.442 төгрөг зарцуулсан. Тус газрын Хиймэл дагуулын мэдээ хүлээн авах газрын станцын антены цамхгийн байр ашиглалтад орсноор ажлын байрны дотоод орчин сайжирсан. Үүнд: давхар бүрт эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн өрөөг шийдсэн. Уулзалтын өрөө, ажилчдын цайны өрөөг шийдсэн. Мэргэжилтнүүдийг хувцасны шүүгээгээр бүрэн хангасан.
2	Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, эд хогшил, техник хэрэгслээр хангах	Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай бичиг хэргийн зардалд 5.896.983 төгрөгийг зарцуулсан. Салбарын хэмжээнд нийт ширээний компьютер 143 ширхэг, зөөврийн компьютер 10 ширхэг, ухаалаг дэлгэц 1 ширхэгийг худалдан авч, 403.330.200 төгрөгийг зарцуулсан. Шинэ байр ашиглалтад орсонтой холбогдуулан гэрээний дагуу газрын дарга, нэгжийн дарга, Ахлах нягтлан бодогч, даргын туслахын өрөөний тавилгыг бүрэн шийдсэн.
3	Төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд шаардагдах мэдээллийг тогтмол шуурхай дамжуулах, тэднийг мэдээллээр хангах зорилгоор "Мэдээллийн самбар", интернэт, дотоод сүлжээ, цахим хуудасны байнгын тасралтгүй ажиллагааг хангах	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулж хамт олны хурлаар хэлэлцэж, тус газрын даргын А/240 дүгээр тушаалаар батлуулсан. Уг хөтөлбөрийн хүрээнд 2022 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг газрын даргаар батлуулж албан хаагч нарт цахимаар танилцуулсан. Мөн Хөдөлмөрийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдуулан тус газрын Хөдөлмөрийн дотоод журмыг ажлын хэсэг шинэчлэн боловсруулж, албан хаагч нартай цахимаар хуралдаж танилцуулан, саналыг хүлээн авч, газрын даргаар батлуулж, дотоод журмыг цахимаар албан хаагч нарт хүргүүлсэн. Албан хаагчдын цалингийн мэдээллийг албан хаагч бүрийн хувийн емейл хаяг руу тогтмол илгээж байна. Албан бичиг, өргөдөл, гомдол, цагийн бүртгэл e.erp-mongolia.mn цахим сайтаар хүлээн авч байна. Төрийн албаны зөвлөлөөс долоо хоног бүрийн Пүрэв гарагт зохион байгуулдаг 7:4:10 арга зүйн цахим сургалтад албан хаагчдаа тогтмол хамруулж байна. Skype, facebook групп, дотоод сүлжээний BeeBEEP мессенжер программаар мэдээ мэдээллийг тогтмол шуурхай дамжуулж байна.

Зорилт 2: Албан хаагчдыг хууль тогтоомжоор олгогдсон нийгмийн баталгаагаар бүрэн хангах, хөдөлмөрийн дотоод журамд заасан дэмжлэг, тусламж, тэтгэмжийг үзүүлэх зорилтын хүрээнд:

1	Албан хаагчдын цалинг ажилласан жилийг харгалзан нэмэгдүүлэх, цол, эрдмийн зэрэг, мэргэшлийн зэрэг дэв, ур чадварын нэмэгдлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Засгийн газраас тогтоосон хувь хэмжээгээр олгох	Албан хаагчдын сарын цалинг сар бүрийн 10, 20-нд 2 удаа олгож байсан. 2022 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт 12 удаа нийгмийн даатгалын тайлан гаргаж 73 албан хаагчаас 06-хүүхэд асрах чөлөөтэй эх-8 албан хаагч 65 ажилчдаас цалингаас даатгуулагч болон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг тооцож Нийгмийн даатгалын хэлтэст эхний 11 сарын байдлаар 236,451.3 мянган төгрөгийн шимтгэл төлсөн. Албан хаагчдад Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын дагуу дараах нэмэгдлүүдийг олгосон. 2022 онд газрын албан хаагчдад эхний 11 сарын байдлаар цалингийн зардлаас үндсэн цалин 688,841.9 мянган төгрөг, зэрэг дэвийн нэмэгдэлд давхардсан тоогоор 83 албан хаагчдад 24,138.7 мянган төгрөг, цолны нэмэгдэлд 13 албан хаагчдад 3,580.7 мянган төгрөг, ур чадварын нэмэгдэлд 191 албан хаагчдад 42,069.6 мянган төгрөг, удаан жилийн нэмэгдэл 286 албан хаагчдад 64,083.0 мянган төгрөг, ажил хавсарсны нэмэгдэлд 46 албан хаагчдад 18,349.2 мянган төгрөг, илүү цагийн нэмэгдэл хөлс 18 албан хаагчдад 2,473.9 мянган төгрөг, 136 албан хаагчдад шөнийн нэмэгдэлийн зардалд 12,081.2 мянган төгрөгийг тус тус олгосон. Төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин Засгийн газрын 2022 оны 192 дугаар тогтоолоор шинэчлэгдээд бна.
2	Хоол, нийтийн тээврийн унааны зардлыг тухайн жилийн төсөвтэй уялдуулан нэмэгдүүлэх	Өдрийн хоол, нийтийн тээврийн унааны зардлыг 2022-01-01-ний өдрөөс нэмэгдүүлж 10,000 төгрөг болгосон. /өмнө 7000 байсан/
3	Орон нутагт томилолтоор ажиллах албан томилолтын зардлыг олгох	Орон нутагт нийт 23 албан хаагч томилолтоор ажилласан. Үүнд 3.299.400 төгрөг зарцуулсан.
4	Албан хаагчдын ажлын бүтээмжийг шударга үнэлэх, ажлын байрны чиг үүргийг оновчтой тодорхойлох, ачааллыг жигдрүүлэх, үйл ажиллагааны үр дүнгээр шууд урамшуулах асуудлыг Засгийн газраас баталсан болон холбогдох бусад журмын дагуу явуулах	Албан хаагчдын 1 дүгээр улиралд хийсэн ажлыг дүгнэж, ажлын гүйцэтгэл, үр дүнг тооцон нийт 69 албан хаагчдад 19,737,782 төгрөгийн урамшуулал олгосон. 2022 оны жилийн эсцийн ажлын тайланг хүлээн авч байна. Ажлын гүйцэтгэл, үр дүнгийн урамшууллыг өгөхөөр төлөвлөөд байна.
6	Төрийн албан хаагчийн ээлжийн амралтыг биеэр эдлүүлэх, ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй албан хаагчид ээлжийн амралтын цалинг нэг аравны тав дахин нэмэгдүүлж олгох	2022 онд ээлжийн амралтаа эдлэх хугацааны талаар албан хаагчдаас саналыг нь авч, газрын даргын 2022 оны А/08 тушаалаар баталсан. Ээлжийн амралтыг нийт 69 албан хаагч амарч, нийт 69,428.3 мянган төгрөгийг олгосон.
7	Ээлжийн амралтаараа өөрийн, эсхүл эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутаг явах бол ирэх, очих замын зардлыг, эсхүл магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр дотоодын сувилалд сувилуулах бол ирэх, очих замын зардлыг тухайн үед мөрдөж байгаа автомашин, төмөр замын үнэлгээгээр тооцож хоёр жилд нэг удаа олгох	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн "12.1.2.ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувиллын газарт, эсхүл өөрийн болон эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутагт амрах тохиолдолд түүний очих, ирэх замын зардал,"-ыг санхүүжүүлэх, зарцуулахыг хориглосон.

8	Албан хаагчдын ажил үүргээ үр дүнтэй биелүүлж, амжилт гаргасан идэвх зүтгэлийг үндэслэн төрийн дээд одон медаль, Засгийн газрын хүндэт өргөмжлөл, Төрийн албаны тэргүүний ажилтан, Байгаль орчны тэргүүний ажилтан, Хүндэт жуух бичиг болон бусад салбарын шагналд тодорхойлох, тус газрын шагналаар шагнах, мөнгөн шагнал, эд зүйл дурсгах	Гавьяат 1, Төрийн дээд одон Алтан гадас одонгоор 7, Байгаль орчны тэргүүний ажилтан цол тэмдгээр 50, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны "Жуух бичиг"-ээр 70, тус газрын Жуух бичгээр 110 албан хаагч тус тус шагнагдсан. Үүнээс ЦУОШГ-ын албан хаагч: Байгаль орчны тэргүүний ажилтан цол тэмдгээр 2, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны "Жуух бичиг"-ээр 4, тус газрын Жуух бичгээр 9 албан хаагч шагнагдсан. Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярын өдрийг тохиолдуулан төрийн одон медалд 15, БОАЖЯ-ны шагналд 37, Сангийн яамны шагналд 3, Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлд 1 албан хаагчийг тодорхойлж явуулаад байна.
9	Албан хаагчид Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу тусламж, дэмжлэг, тэтгэмж, нөхөн олговор олгох	Ар гэрийн гачигдал гарсан 6 албан хаагчид нийт 1.800.000 төгрөгийн тусламж олгосон. Тус газрын Ахмадын хороонд бүртгэлтэй өндөр настнуудад Сар шинийн баяр, Дэлхийн болон Монголын ус, цаг уурын өдрийг тохиолдуулан 103 ахмад настанд нийт 4.120.000 төгрөг, Ахмадын өдрийн тохиолдуулан 105 ахмад настанд 4.200.000 төгрөгийн тусламж олгосон. 2022 онд 3 албан хаагчийн өндөр насны тэтгэвэрт нийт 71,097.40 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна . Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж 5 хүний 569,9 мянган төгрөг олгосон байна.
10	"Эцэг эхийн зөвлөл"-ийг ажиллуулах, үйл ажиллагааг нь дэмжих	Эцэг эхийн зөвлөлийн саналын дагуу тус газрын Хөдөлмөрийн дотоод журамд 4.2.1.5, 4.2.1.6 гэсэн заалтуудыг оруулж өгсөн. Засгийн газрын 2021 оны 388 тогтоол, төсвийн хэмнэлтийн улмаас тус газрын Хөдөлмөрийн дотоод журмын 4.2.1.5 дахь заалтын дагуу албан хаагчдын 16 наснаас доош насны хүүхэд бэлэг өгөөгүй. Хүүхдийн өрөө байгуулахаар хэлэлцээд байна.
11	Албан үүргээ гүйцэтгэх явцад төрийн албан хаагчийн амь нас хохирсон тохиолдолд 60 сарын албан тушаалын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламжийг түүний ар гэрт нь олгох	- Байхгүй
Зорилт 3: Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, тэдэнд бие бялдар гоо зүйн төлөвшил олгох зорилтын хүрээнд:		
1	Албан хаагчдыг өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх зорилгоор жилд нэг удаа эмнэлгийн үзлэгт хамруулах, үүнтэй холбогдон гарах зардлыг газрын урсгал зардлаас гаргах	Төсвийн хэмнэлтийн горимд шилжин ажиллаж байгаатай холбогдуулан байгууллагаас гаргах урсгал зардлыг хэмнэсэн тул уг ажлыг зохион байгуулахад хүндрэлтэй болсон. Төрөөс хувь хүн болгоныг багцын шинжилгээнд хамруулж байгаатай холбогдуулан албан хаагчдыг шинжилгээ хамруулах боломжоор хангаж чөлөө олгож ажилласан.
2	Эрүүл мэндээ хамгаалах, төрөл бүрийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн мэдээ, мэдээллийн булан цахим сайтад ажиллуулах	Байгууллагын цахим сайтад эрүүл мэндийг хамгаалах, мэдээлэх цахим сайтын линкийг холбох ажлын хүрээнд судалгаа хийгдэж байна.

3	Албан хаагчдыг жилд 2-оос доошгүй удаа эрүүл агаарт аялах ажлыг зохион байгуулж, холбогдох зардлыг санхүүжүүлэх	Тус газрын албан хаагчид цаг уурын баярыг тохиолдуулан Төв аймгийн Мөнгөнморьт суманд ажиллаж, аялсан. Албан хаагчид өөрсдөө зардлаа гаргасан.
4	Албан хаагчдыг чийрэгжүүлэх зорилгоор долоо хоног бүр спорт зааланд тодорхой цаг авч, спортын арга хэмжээ зохион байгуулах	2022-01-01-ээс 2022-05-31-ний өдрийг дуустал Онцгой байдлын ерөнхий газартай хийсэн гэрээний дагуу Аврагч биеийн тамир спортын хорооны зааланд тус газрын албан хаагчид Даваа гараг бүрийн орой 1,5 цаг авч, албан хаагчдыг чийрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан. Шинэ байранд хувцас солих, шүршүүр, ариун цэврийн өрөөтэй мини спорт заалтай болсон.
АЛБАН ХААГЧДЫГ КОВИД-19 ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙХ АЖИЛ		
1	Эрх бүхий байгууллагаас баталсан шийдвэр, хорио цээр, хөдөлгөөний болон цагийн хязгаарлалтын дэглэм, заавар, журам, шаардлага, сэрэмжлүүлэг, анхааруулга, зөвлөмжийг сахин биелүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах	Эрсдэл бүхий үйл ажиллагааны үед /хурал, сургалт/ халдвар хамгааллын дэглэм барьж ажиллаж байна.
2	Ажлын байранд агааржуулалт, ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, албан хаагчдын дархлаа, эрүүл мэндийг дэмжих ажлыг зохион байгуулах	Коронавируст халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлэхэд зориулж маск, гар ариутгагч худалдан авч албан хаагчдад тараахад нийт 930,000 төгрөг зарцуулсан.

ДАРГА

С.ЭНХТҮВШИН

ХЯНАСАН: ЗАХИРГАА, АУДИТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Н.ГАЛЦОГ

ТАЙЛАНГ БИЧСЭН: ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ж.ЭНХЧИМЭГ